

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,  
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны 04 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар А/321, А/246, А/81

Улаанбаатар  
хот

Цаг уурын хүнд нөхцөлтэй гэж үзэх гадаад улсын  
жагсаалтыг шинэчлэн батлах тухай

Дипломат албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн  
ТУШААХ НЬ:

1. Дипломат албаны тухай хуульд заасан “Цаг уурын хүнд нөхцөлтэй” гэж үзэх гадаад улсын жагсаалтад Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Арабын Бүгд Найрамдах Египет Улс, Бүгд Найрамдах Куба Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Тайландын Вант Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Кувейт Улс, Бүгд Найрамдах Индонез Улс, Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс болон Арабын Нэгдсэн Эмират Улсыг оруулан шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалыг батлагдсантай холбогдуулан Гадаад харилцааны сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын “Цаг уурын хүнд нөхцөлтэй орны жагсаалт батлах тухай” 2014 оны А/81/А89/286 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАДААД ХАРИЛЦААНЫ  
САЙД  
*Б.Батцэцэг*  
Б.БАТЦЭЦЭГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД  
*С.Энхболд*  
С.ЭНХБОЛД

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД  
*А.Ариунзаяа*  
А.АРИУНЗАЯА

Цахим ашигтэй хувь

Гадаад харилцааны төв архив